

**“Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” хэмээх
аман бичвэрийг шинжлэх нь**

Ганбаатарын НАНДИНБИЛИГ*
МУИС, ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын
Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Received: May 10, 2024

Revised: Jun 13, 2024

Accepted: Jul, 15, 2024

Хураангуй: Тус өгүүлэлд хуучин “Засагт хан аймгийн Дайчин засгийн хошууны урианхануудын үр хойчсын дунд өвлөгдөж ирсэн эртний монголчуудын аравтын системийг санагдуулам 100 буудалт шатартай шууд холбогдох “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” хэмээх шинэхэн олдоод буй аман зохиолын жишээг задлан шинжилж, төрөл зүйлийг судлан тогтоохыг зорьсон болно. Тус өвөрмөц туурвилд газар ус үүсэхийн өмнө Наран Бумбын орноос шороо атган авч газар дэлхийг бүтээсэн тухай, Саран зүйдэлгүй орноос усыг завьяалан дээжилж, хур бороо оруулснаар дөрвөн далайг бүтээсэн тухай, Хурмастын найр дээр Тэнгэр нарын өмнө Наран Саран хоёр тангараг тавин, энэ газар дэлхийн эзэн сахиул болсон тухай, эх болсон газар ерэн дүнчүүр насыг хурааж энх амгалан оршиж байтал харь тивийн хий барам халдан эзэлсэн муу цаг ирсэн тухай, Тэнгэр нар харь тивийн муу бармуудыг хөөж газар дэлхийг аварсан тухай, мангас дайсны аюулыг мартахгүй санаж байг гэж тэнгэр эрхсээс шатар бүтээж өгсөн тухай, монгол шатрын жаягийн тухай, шатрын андгай тангаргийн тухай өгүүлж байна. Бидний үзэхээр энэхүү “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль”-ийн эхний гурван бүлэг нь ертөнцийн үүслийн домог зүйтэй холбогдож байгаа бол сүүлийн гурван бүлэг нь шатар үүссэн тухай соёлын үүслийн домог зүйн жишээ мөн байна.

Түлхүүр үг: Монгол аман зохиол, миф-эртний домог, баатарлаг туульс, шатар

* © Г.Нандинбилиг

Email: nandin@num.edu.mn.

Analysis of narrative text “wooden chess with the blue elder icon”

NANDINBILIG Ganbaatar

Department of Literature and Arts Studies, Branch
of Humanity, School of Science, NUM

Abstract: The article analyzes and defines the genre of the narrative text “Wooden chess with the blue elder icon” which is directly related to the 100-station folk chess of the ancient Mongols. It was inherited among the descendants of the Uriankhans in the Daichin Zasag Hoshuu of Zasagt Khan Province. In this unique story, before the creation of land and water, the Sun created the Earth by transporting dirt from Bumba's land and the Moon sacrificed water from the land of the Gods and created the four oceans by sending rain, and the Sun and the Moon brought water from Zuidelgui land and dispersed it into the sky where it manifested as rain that created the four oceans, the Sun and Moon swore an oath in front of the Heavens at the feast of Khurmast that they would become the Lord of the Earth, where the sun would protect the earth in the day and the moon would in the night so that the Mother Earth was living in peace for nine billion years, a period called the feast, then suddenly from a distant foreign continent demons invaded to seize the Earth in a period known as the ruin, The Heavens intervened in the war as mankind, the sun, and moon were on the brink of defeat, expelling the demons from the Earth, from there, to retain the knowledge of the war with the demons, the Sun, Moon, and the Heavens created chess. For this reason there are white and black sides to chess to develop man's intelligence. From this we conclude that “Wooden chess with the blue elder icon” is not a heroic epic but rather a myth where the power of the Heavens are greater than that of mankind. The first three chapters of this story are related to the mythology of the origin of the world, while the last three chapters are the mythological version of the origin chess.

Key words: Mongolian folklore, ancient myth, heroic epic, chess

Удиртгал

Монгол шатрын тухай хамгийн эртний мэдээллийг хадгалсан “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” хэмээх туульсыг 2022 онд шатар судлаач А.Батзориг эртний монголчуудын Эшт шатрыг сурвалжилж явахдаа Говь-Алтай аймгийн Шарга сумын харьяат Пунцагийн Ядам гэж настнаас тэмдэглэн авч, 2023 онд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын тамгын газраас хамтран зохион байгуулсан “Засагт хан аймгийн Дайчин засгийн хошууны түүх соёл” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн “Дайчин засгийн хошууны урианханууд эртний монголчуудын Эшт шатрын өв тээгчид болох нь” илтгэлийнхээ хавсралтад хэвлүүлснээр судалгааны эргэлтэд оруулсан байна.

Судлаачийн мэдээлснээр “Говь-Алтай аймгийн Дарви сумын уугуул Ванчигийн Төмөрбаатар 2021 оны 11 дүгээр сарын 25-нд удам дамжин

хадгалагдаж ирсэн нэгэн шатрын талаар мэргэжлийн дүгнэлт хийлгэх хүсэлт гаргаснаар монголчууд *Их шатар*, *Бүтэн шатар*, *Бага шатар* гэсэн гурван төрлийн шатар тоглодог байсан, шатрын тухай тусгай туультай байсан, эртний монгол шатрын өв тээгчид энэ цаг үед амьдарч байгаа нь судалгааны явцад тодорхой болсон” (Батзориг, 2023: 127) бөгөөд “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль”-ийг хэлж өгсөн “П.Ядам нь урианхан хүн бөгөөд энэхүү туулийг ээж Ө.Ширчингээсээ сурсан байна. Ээж Ө.Ширчин нь болохоор өөрийн эцэг Өлзийгийн ах, “Шатар” хэмээх Найдангаас өвлөжээ. 85 настай П.Ядам “Хамтын хүч” багийн Шатрын хөндий хэмээх газарт хэдэн үеэрээ амьдарч байгаа” (Батзориг, 2023: 126-142) ажээ.

“Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” нэрээр уламжилж ирсэн аман зохиолын энэ жишээг бид үгийн урлагийн өвөрмөц хэлбэр болох талаас нь мэргэжлийн задлан шинжилгээ хийж, аман зохиолын чухам ямар төрөл зүйлд хамаарахыг судлан тогтоохыг зорьж байна.

Үндсэн хэсэг

1. “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” дахь домгийн цаг ба орны тохиргоо

“Хөх өвгөн сахиустай Хөл модон шатрын тууль” нь “Газар дэлхий үүсэв” хэмээх тэргүүн бүлэг, “Дайн болов”, “Тэнгэрийн аврал”, “Шатар үүсэв”, “Шатрын жаяг”, “Шатрын тангараг” хэмээх таван дэд, нийт зургаан бүлэг, 97 бадаг, 388 шад шүлгээс бүрдэх бөгөөд “Газар дэлхий үүсэв” хэмээх тэргүүн бүлэг эхлэхдээ:

Эртээ урьдын цагт
Элэнц хуланцын үед
Гүн далайг шалбааг байхад
Гүлбир модыг нахиа байхад
Замын эхэн зураас байхад
Жангар хүүг төрөөгүй байхад (ЗХАДЗХТС, 2023:132)

гэхчлэн олон монгол туульсын адил домгийн цагаар эхэлж байна. Гэхдээ “Сүмбэр уулыг дов байхад, сүн далайг шалбааг байхад захын модыг зулзага байхад загал бугыг янзага байхад” гэдэг монгол домгийн цагийн аман хэвшилт шүлгээс бага зэрэг ялгаатай буюу сүмбэр уул, загал бугын дүрийг дурсаагүйгээр барахгүй монгол туульсын Жангар баатрыг дурдахын хамтаар үйл хэрэг өрнөх орныг дүрслэхдээ:

Сэр сэр хийсэн салхитай сэрүүн оронд
Бур бур хийсэн хуртай Бумбын оронд
Наран Саран хоёр уулзаж гэнээ
Найрлан суусаар удаж гэнээ (ЗХАДЗХТС, 2023:132)

гэж Жангар туульст гардаг Бумбын оронд буюу хүний ертөнцөд үйл явдал болж байгаагаар эхэлж байна. Бүр тодруулбал найрлан суусаар удаж байгаа энх амгалангийн орон, цагаар эхэлж байна.

2. “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” дахь домог зүйн дүрүүд

Тус туульс нь монгол домог зүйн хос дүрүүд болох Наран, Саран хоёр эрхэс Бумбын оронд уулзан найрлаж байгаа өгүүлэмжээр эхэлж байгаа бөгөөд цааш үргэлжлэхдээ:

Хул тавилгүй айраг уусан
Хутга тавилгүй мах идсэн
Хундага амралгүй сархад зооглосон
Хурмастын найр болж гэнээ
Баруун талын зочид нь гэвэл
Бардаад ирдэг баатар цагаан тэнгэрүүд юм гэнэ
Зүүн талын зочид нь гэвэл
Зүтгээд ирдэг зүрхэн хар тэнгэрүүд юм гэнэ (ЗХАДЗХТС, 2023:133)

гэхчлэн найрын зочид нь эрт язгуурын бөө мөргөлийн барууны цагаан, зүүний хар тэнгэрүүд зүг зүгтээ залран байгаагаар өгүүлсэн байна. Хурмастын найр болж, найрлан суугаа тэнгэр нарыг өнгө, зүгээр нь ялган маш тодорхой танилцуулсан энэ хэсэг бол олон монгол баатарлаг туульсын домгийн удиртгалд төдийлөн байдаггүй өвөрмөц эхлэл бөгөөд Хурмастын найрын зочин тэнгэр нарыг яг л монгол гэрт монгол найрын дэг ёсоор найрлан суугаа байдлаар дүрсэлсэн нь сонирхолтой байна. Энэ нь мөн “Монгол домгийн баруун зүгийг ивээгч тэнгэр нар голдуу цагаан өнгөтэй байхад зүүн зүгийн харш тэнгэр нар болохоор бараан өнгөтэй байдаг”(Дулам, 1989: 72) уламжлалтай нийцэж байна.

3. “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” дахь ертөнцийн үүслийн домгийн өгүүлэмж

Энэхүү туулийн домог зүйн удиртгалд Хурмастын найр дээр Наран, Саран хоёр эрхэс газар дэлхийг бүтээсэн гэж өгүүлж байна. Жишээлбэл:

Алтан Наран өндийн босоод
Ам гаран өгүүлэв гэнэ
Алаг хөрсөн шороотой
Алтан дэлхий нь энэ ээ гээд
Бур хийх шороотой Бумбын орноос
Базан авч атгахад
Бүлтэн дэлхий үүсэж гэнэ
Бөөр хэлбэртэй харагдаж гэнэ
Зах нь сэмрээгүй тэнгэрийн орноос
Залтас олон хамт атгахад
Замбуутив үүсэж гэнэ
Заан дүртэй харагдав гэнэ.
Мөнгөн Саран удаалж босоод
Мэндийн үйлээ хийж дуусаад
Мэлмий тунарах их усан
Мандал далай нь энэ ээ гээд
Зүр их устай зүйдэлгүй орноос
Завьяалан авч дээжлэхэд

Дөмөг хур орж гэнэ
Дөрвөн далай үүсэж гэнэ (ЗХАДЗХТС, 2023:133)

Энэ нь Дулам профессорын судлан тогтоосон ертөнцийн үүслийн домгийн (Дулам, 1989: 72) дүр өгүүлэмжүүдээс ялгаатай өвөрмөц хувилбар байгаа хэдий ч уран сэтгэмжийн учир зүйгээрээ маш үнэмшилтэй домог байна. Өмнө судлан тогтоосон домгийн хувилбарт Бурхан Чөтгөр хоёр туурвигч баатрын зөрчил тэмцлийн дүнд газар дэлхий бүрэлдэж байдаг бол энэ домогт Наран нь газар дэлхийг, Саран нь дөрвөн далайг тус тус бүтээж байна. Мөн домог зүйн туслах туурвигч баатар болох Хайрханы оронд “Зах нь сэмрээгүй тэнгэрийн орноос залтас олон хамт атгахад замбуутив үүсэж” байна. Газар дэлхийг бүтээхдээ Наран эрхэс Бумбын орноос анхны шороог атган авчирч байгаа бол Саран эрхэс зүйдэлгүй орноос усыг завьяалан авч дээжилснээр хур бороо орж, дөрвөн далайг үүсгэж байна.

Цаашилбал Хурмастын найр дээр Наран, Саран хоёр эрхэс энэ газар дэлхийг өдөр шөнийн цагаар ээлжлэн сахиж харж байхаар тэнгэр нарын өмнө ам тангараг тавьж байна.

Тус туульд өгүүлснээр:

Алтан Наран өндийн босоод
Амь орсон алаг газрыг
Өдрийн гэгээн цагаар
Өөрийн илчээр дулаацуулна гэж
Саран авхай саатан босож
Сүр орсон алаг тивийг
Шөнийн сэрүүн цагаар нь
Сахин хамгаалж явна гэж
Тангараг тавин хэлэв гэнэ
Андгай болгон амлав гэнэ
Ацаг болгон тамгалав гэнэ
Ажил болгон дагав гэнээ (ЗХАДЗХТС, 2023: 134)

гэхчлэн газар дэлхийг Наран эрхэс нь өдрийн цагаар дулаацуулж, Саран эрхэс шөнийн сэрүүн цагаар сахин хамгаалж байх тангараг тавьж байна. Наран Саран хоёр энэ дэлхийг хамтран бүтээгээд, тэнгэр нарын өмнө түүнийгээ харж сахиж явах тангараг тавьж байгаа энэ өгүүлэмж бол одоогоор олдоод байгаа аман зохиолын жишээн дотор яг энэ хэллэгээрээ тохиолдож байгаагүй бөгөөд монгол домог зүйн уран сэтгэмжийн үүднээс аваад үзвэл яах аргагүй ертөнцийн үүслийн монгол домгийн нэгэн тасархай мөн байна.

“Газар дэлхий үүсэв” хэмээх эхний бүлэг төгсөхдөө:

Ай гэх айдасгүй
Амгалангийн орон нь энэ юм зээ
Ий гэх зовлонг
Энхжингийн орон нь энэ юм зээ...
Амь орсон алаг газар нь
Арван дүнчүүр насыг элээв

Эх болсон энэ газар

Ерэн дүнчүүр насыг хураав (ЗХАДЗХТС, 2023:134)

хэмээн алтан Наран эзэнтэй, мөнгөн Саран сахиултай энэ дэлхий энх амгалангаар өнө удаан жил тогтносныг өгүүлэхийн хамтаар өнө удаан жаргалын дараа удахгүй самуун цаг ирэхийг дохиолоод төгсөж байна.

4. “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” дахь их дайны өгүүлэмж

Монгол аман зохиолын гүн ухаанд өнө мөнхийн энх амгалан гэж үгүй бөгөөд жаргал, зовлон ямагт ээлжилж байх энэ ертөнцийн жамыг “Жаргал-зовлон-жаргал” буюу жаргалаар эхэлж, жаргалаар төгсдөг сондгой тооны даваат туульсаараа сургадаг. “Дайн болов” хэмээх удаах бүлэгт:

Хамаг эзэд амарсан хойно

Харуй бүрий үүрээр гэнэ

Хэлж ирдэггүй хий барам

Халдан ирж довтлов гэнэ (ЗХАДЗХТС, 2023:135)

гэхчлэн энх амгалангийн сайн цаг төгсөж, муу цаг ирснийг хэлж байна. Энд халдан довтолж ирсэн дайсан этгээд буюу сөрөг дүрийг олон монгол туульст үзүүлдэг шиг “мангас” гэсэнгүй, “хий барам” буюу шашны хийсвэр хар хүчин болохыг шууд хэлсэн байна. Барам (тө. раг та) гэдэг нь төвөд хэлний үг бөгөөд монгол хэлэнд “1. Гүрэм хийхэд хар гурилаар барьдаг нэг зүйлийн ад чөтгөрийн дүрс, 2. хараал үг”(Сүхбаатар, 1999) гэсэн утгаар хэвшсэн байна. Хий бармын халдаж ирсэн цаг нь ч “Үүрийн харуй бүрий цаг” гэж бодит амьдрал дээр хэлбэл хэн хүний гүн нойрны цаг, монгол соёлын цагийн бэлгэдлээр бол “авах алдахын дэнс” бар цагийг гэж хэлж байна. Үүнээс үзвэл Эшт шатрын сөрөг дүр нь нэг зүйлийн ад чөтгөрийн зүйл буюу домог зүйн хийсвэр хар хүчнийг зааж байна.

Мамын толгой эрмээлжтэй

Мангасын арьсан хударгатай

Сэнгэ данжин жолоотой

Сүгсрэн данжин цулбууртай

Муу газрын мянган барам

Могойн дүрээр ирэв гэнэ

Харь газрын түмэн барам

Хачиг хувалзаар дүрлэв гэнэ.

...Даян дэлхийн хөмөг газар

Дайн самуун дэгдэж гэнэ (ЗХАДЗХТС, 2023: 135)

Энэ хэсэгт бидний анхаарлыг хамгийн эхэнд татаж байгаа зүйл бол хорчин монголчуудын “Галавын үлгэр” (Dulam, Vasek, 1983: 152) хэмээх домог зүйд тэнгэрээс хувилж газарт буусан хоёр тэнгэр буюу Сэнгэ Донран (Арслан толгойт), Шүүсрэн Донран (Матар толгойт) хоёрыг “Сэнгэ данжин”, “Сүгсрэн данжин” хэмээн нэрлэн дурдаж буй явдал юм. Энэ хоёр бол газар дэлхий дээр хүний омгийг аврахаар тэнгэрээс мангаст хувилж, Сам (Лхам) бурхны хоёр хүү болж хувилж төрсөн тэнгэрүүд юм. “Лхам бурхан бол буддын шашны арван хангал догшин бурхны нэг боловч Галавын үлгэрт болохоор газрын

самууныг дарахаар тэнгэрээс мангаст хувилж төрсөн ганц эмэгтэй баатар гэж гардаг. Лхам бурхан мангасын эхнэр болоод хоёр хүү хувилгаж, нэг охин төрүүлсэн бөгөөд баруун зүүн хоёр сугаар гарсан хоёр хүү нь тэнгэрийн хувилгаан байж, умайгаас төрсөн охин нь мангас байдаг. Сам шинэ төрсөн мангас охиныхоо толгойг нь тастан, шөрмөсийг нь сугалж алаад, шөрмөсөөр нь дөрөөний сур, дөрвөн ганзагаа хийж тохоод явдаг. Энэ өгүүлэмж нь Бурхан шашны Балданлхам бурхны хөрөг зургийн өгүүлэмжтэй үндсэндээ таарах бөгөөд энэ аймшгийн дүр байдал, зан төрх нь мангасын хар хүчийг биедээ эзэмдсэнээр тэднийг ялан дийлэх учир зорилготой уялдаж байдаг. Лхам бурхан хүүхдүүдтэйгээ мангасыг хүлж авчраад, цусан далайд дарсан ч тэнгэртээ буцалгүй, мангасаас хүнийг сахин хамгаалахаар газарт үлдсэн баатрууд гэж гардаг билээ” (Нандинбилиг, 2019: 128). Муу зүгийн бармыг “Мамын толгой эрмээлжтэй, мангасын арьсан хударгатай, Сэнгэ данжин жолоотой, Сүгсрэн данжин цулбууртай” гэсэн энэ дүрслэл нь Лхам бурхны хоёр дагуулын нэрс болоод мангас охины толгойг тастан, шөрмөсөөр нь дөрөөний сур, дөрвөн ганзага хийж тохоод явдаг домгийн өгүүлэмжийг санагдуулж, эдгээр домгийн хооронд нэгэн сэжиг холбоо байгааг мэдээлж байна.

Тус туульд хар муу хүчнээс газар дэлхийгээ хамгаалсан хэцүү бэрх домог зүйн дайныг өгүүлэхдээ:

Өтөл хөгшид мөслөн дайтав

Өнөд залуус сульдэн дайтав...

Алтай, Хангай өндийн дайтав

Хөхүй хангай хөвчлөн дайтав

Дөрвөн далай шуугин дайтав

Дэвэн дэлхий бүтэн дайтав

Алтан наран бүрхэн дайтав

Мөнгөн саран хиртэн дайтав (ЗХАДЗХТС, 2023:135)

хэмээн хүн зон хийгээд дэлхийн эзэн болсон Наран, Саран хамтдаа муу зүгийн Бармыг дарахаар дайтаж байснаар өгүүлжээ. Домог зүйн дайн бол олонхдоо хар цагаан зүгийн хийсвэр хүчнүүдийн хоорондын дайн байдаг бөгөөд “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын туульс”-д өгүүлж байгаа дайн нь газар дэлхийгээ хар хүчнээс хамгаалахын төлөөх дайн байгаа бол хорчины “Галавын үлгэр”-т гардаг дайн нь хүний махаар хүнсэлдэг мангас махчнаас хүний омгийг хамгаалахын төлөө хийсэн тэнгэр нарын дайн байдаг.

Буурын шүдээр хавиралцаж дайтав

Бухын нүдээр хялайлцаж дайтав

Азарганы хөлөөр гишгүүлж дайтав

Арслан барсаар уруулан дайтав (ЗХАДЗХТС, 2023:135)

Энэ хэсэгт дайсагнагч хоёр талын зөрчлийг үзүүлэхдээ буур, бух, азарганы уур хилэнтэй адилтгаж, Эшт шатрын тэмээ, тэрэг, морины нүүдлийг сэдэлжүүлсэн байна. Тэмээний нүүдлийг дүрслэхдээ “Буурын шүдээр хавиралцаж” гэж, тэрэгний нүүдлийг дүрслэхдээ “Бухын нүдээр хялайлцаж” гэж, морины нүүдлийг дүрслэхдээ “Азарганы хөлөөр гишгүүлж” гэхчлэн

монгол бөөгийн аман яруу найрагт тохиолддог хатуу ширүүн хэллэгийг хэрэглэсэн байна. Жишээлбэл, дархад бөөгийн уламжлалд Татайн хөх тэнгэр хэмээх онгодын тамлагад “Бухын нүдээр хялайлцаж, буурын шүдээр хавиралцаж, буруу тангараг тавилцаж” (Дулам, 1992: 118) гэж дууддаг.

“Тэнгэрийн аврал” хэмээх дараах бүлэгт энэ их хэцүү дайнд хүн төрөлхтөн хүчин мөхөстөж байхад тэнгэр нар ирж муу зүгийн дайсныг нь дарж өгсөн тухай:

Хөх тэнгэр өмөгтөнгүүд ирэв
Хөвөн үүл нөмрөгтөнгүүд залрав
Тивэн зах суудалтангууд ирэв
Тэнгэр хаяа чуулгалангууд залрав
Муу газрын мянган бармыг
Муна шийдмээр балбаж гэнэ
Могойн бүрэг дүрээс нь
Манж салган хөөж гэнэ
Хөх тэнгэрийн өмөгтэй
Хөр газар нь энэ юм зээ
Харь тамын дайсантай
Хар газар нь энэ юм зээ (ЗХАДЗХТС, 2023:136)

гэхчлэн өгүүлснээс үзэхэд газар дэлхийг “Муу зүгийн мянга түмэн барам”-ын аюулаас авран салгасан ачтан нь хүн биш, Тэнгэр нар болж байна.

5. “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль” буюу шатрын үүслийн домог

“Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын тууль”-ийн “Шатар үүсэв”, “Шатрын жаяг”, “Шатрын тангараг” гэсэн сүүлийн гурван бүлэг нь “Шатар үүссэн тухай” соёлын үүслийн монгол домгийн жишээ мөн байна.

Дайснаа танихгүй далиу ухаантай
Өстнөө ялгахгүй өнчин бодолтой
Гайтнаа мэдэхгүй гажуу ухаантай
Буруутнаа олохгүй балчир бодолтой
Махан биетэй хүрэн зүрхтэнгүүд (ЗХАДЗХТС, 2023:137)

гэж хүнийг дүрсэлсний цаана хүн төрөлхтөн дайснаа эндүүрч нөхөрлөөд, хэрхэн алдаа эндэлд орсон тухай дэлгэрэнгүй өгүүлэмж байсан нь мартагдаж гээгдсэн бололтой байна.

Мангас дайснаа санаж байг гэж
Дайнд ялсан тэнгэр нь бэлдэж
Дайснаа дарсан эрхэс нь урлаж
Ухаан залах өвгөдөд даатгаж
Усан нүдэн мэлмийтэнд зориулж
Модон хөлөгтэй ясан дүртэй
Монгол шатрыг бүтээв гэнэ.
Амь булаалдах дайн юуг нь

Арга булаалдах наадгай болгов
Уур булаалдах дайн юуг нь
Ухаан булаалдах наадам болгов (ЗХАДЗХТС, 2023:137)

хэмээн шатар үүссэн учрыг эрт цагийн их дайн самууныг дарж өгсөн тэнгэр, эрхэс нараас хүн төрөлхтөнд арга ухаан суулгах гэж шатрыг бүтээж өгсөн гэж тайлбарлажээ.

Монгол шатар нь ноён, бэрс, тэмээ, тэрэг, морь, хүү гэсэн зургаан төрлийн дүрстэй бол Эшт шатар нь хаан, шадар, бэрс, тэмээ, морь, тэрэг, хүү гэсэн долоон төрлийн дүрстэй ажээ. Судлаач А.Батзоригийн мэдээлснээр “Эшт шатрын нэг тал нь 10 хүү, тэрэг, морь, тэмээ, бэрс тус бүр хоёр, шадар нэг, хаан нэгтэй байна” (Батзориг, 2016).

“Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын туульд”
Алтан тамгат хөлөг юуг нь
Арван цэргээр мануулав гэнэ
Хөлгөн сахиус Хөх өвгөнийг
Хааны дайтай өргөмжлөв гэнэ

гэснээс энэ шатрын хөлгийн бүтэц 10х10 буюу 100 буудалтай нь тодорхой харагдах” (Батзориг, 2016) бөгөөд шатрын арван хүүгийн үндсэн үүрэг нь газар нутгаа манах гэсэн санааг илэрхийлж байна. Мөн түүнчлэн:

Хөлгөн сахиус Хөх өвгөнийг
Хааны дайтай өргөмжлөв гэнэ (ЗХАДЗХТС, 2023:138)

гэж Эшт шатрын тэргүүн дүр Хааны дүрд хөлгөн сахиус буюу газар нутгийн эзэн нь Хөх өвгөнийг өргөмжилж байна. Хөх өнгө нь монгол үндэстний ижилслийг илтгэх соёлын тэмдэг бэлгэдлийн судалгааны дүнгээс үзэхэд “Монгол” гэсэн утгыг илтгэдэг” (ҮБЗ., ММСГ., МУИС- УЗУСТ., 2018). Энэ утгаар үзвэл туульст гарч байгаа хөлгийн сахиус Хөх өвгөний дүр бол “Монгол хүн” болж таарч байна.

Эшт шатрын Хаан бол монгол шатрын Ноёноос давуу өргөмжлөл болох тул Хаанд туслах Шадар хэмээх дүрсийг нэмэлтээр гаргажээ. “Шадар гэх нэмэлт бод нь тэрэг, тэмээ, морь шиг нүүдгээрээ онцлог. Өөрөөр хэлбэл шатрын бүх дүрсийн нүүдлийг ганцаар хийж чаддаг бөгөөд хамгийн ашигтай байрлалд байхад 100 нүдний дөчийг ганцаараа хянах боломжтой хүчирхэг дүрс” ажээ. Туульсын шүлэглэлд энэ тухай мэдээлэхдээ:

Уургүй хаанд хиалан шадарлах
Ухаан тэлсэн баатар эрд
Хаан болсон Хөх өвгөнийг
Хаа ч явсан хамгаал гэж
Ариг буурын шидийг өгөв
Агсал азарганы нүүдлийг өгөв
Агсан бухын хүчийг өгөв
Арван цэргийн манлай болгов (ЗХАДЗХТС, 2023:138)

гэхчлэн өгүүлснээс үзвэл Эшт шатрын Шадар хэмээгч нь шатрын хөлөг дээр

тэмээ, морь, тэрэгний нүүдлээр нүүх эрхтэй хүчирхэг баатрын дүр байна.

Цаашилбал Эшт шатрын хоёр тэмээний өргийг:
Аржгар буур нь зэнгэрлэн өрж
Цагаан хөлийг эзэгнэв гэнээ
Баржгар буур нь сэвслэн шавж
Бараан хөлийг эзлэв гэнээ” (ЗХАДЗХТС, 2023:138)

гэсэн бол тэмээний нүүдлийг:

Орсон буур нь сэвслэн нүүг
Онгодын буур нь зэнгэрлэн нүүг (ЗХАДЗХТС, 2023:139)

хэмээн монгол бөөгийн аман зохиолд онгодын уур хилэнгийн бэлгэдэл болж байдаг орсон буурын дүр төрхөөр үзүүлжээ.

Харин Эшт шатрын хоёр морины өргийг:
Тэнгэрийн хүлэг Цолмон хүрэн
Дээрээс ирж хөлөгт сойгдов
Лусын эзний ногоон луус
Луун хүрхэрч, цамнан цавчлав (ЗХАДЗХТС, 2023:138)

гэж шатрын хоёр морины нэг нь хүрэн зүстэй тэнгэрийн хүлэг байдаг бол нөгөө нь ногоон зүстэй лусын эзний луус байдгийг таниулаад, морины нүүдлийг:

Армаг хүлэг нь хашин нүүг
Агсан азарга нь цавчлан нүүг (ЗХАДЗХТС, 2023:139) гэж,
Эшт шатрын хөлөг дээрх тэргийг дүрслэхдээ:
Уулын эзэн сарлагийн бух нь
Талын эзэн улаан бух нь
Ойн эзэн хүрэн буга нь
Хөвчийн эзэн хүрэн манж нь
Дөрвөн талыг дааж гэнэ (ЗХАДЗХТС, 2023:138)

хэмээн газар нутгаа дөрвөн талаас нь буга, баавгай хоёрын хамтаар хамгаалж байдгаар өгүүлсэн байна. Энэ дүрслэлд тэргэнд хөллөх сарлаг, монгол хоёр үхрийг ялган өгүүлсний зэрэгцээ буга, баавгай хоёрыг дурдаж байхаас үзэхэд Эшт шатрын анх эртний уламжлалд буга, баавгай зэрэг дүрс бас байсан ч байж магадгүй байна.

Дөрвөн далай шуугьж гэнэ
Хангай дэлхий баясаж гэнэ
Хамаг Лус баярлаж гэнэ
Тэнгэрийн эздийн хүслээр бүтээсэн
Тарлан хөлтэй шатар нь энэ юм зээ
Лусын эздийн хүслээр бүтээсэн
Луун хээтэй шатар нь энэ юм зээ...
Хоёр тал нь талцан нүүг
Хорвоо дэлхийг баясган нүүг ээ (ЗХАДЗХТС, 2023:139)

хэмээн шатраа магтаж, нүүдлээ хөгжөөж буй энэ хэсгээс шатар тоглоход хангай дэлхий, лус савдаг баярлаж байдаг гэсэн эртний итгэл бишрэл, зан

үйлийн улбааг ч олж харж болно. Үүнийг өмнө өгүүлсэн домог зүйн учир зүйгээр тайлбарлавал шатар тоглох нь муу зүгийн мянган бармыг дарж, Наран эрхсийн бүтээж өгсөн хангай дэлхий, Саран эрхсийн бүтээж өгсөн ус лусыг баясгаж байгаа зан үйлийн утгатай болж байна.

Эшт шатрын зан үйлийн шинжтэйг “Шатрын жаяг”, “Шатрын тангараг” хэмээх удаах бүлгүүдэд мэдээлсэн гарааны нүүдлийн жаяг хийгээд нууц ёгт дохио, далд утгууд улам бүр баталж байна. “Монгол шатар цагаан талаас эхэлж нүүдэг хүндэтгэлийн хэлбэртэй ч Эшт шатрын тухайд хар тал нь эхэлдгээрээ онцлог ажээ. “Шатрын жаяг” хэмээх удаах бүлэгт үүний учрыг

Ах захаа мэдэг гэж
Алтан тал нь эхэлж байг
Алаг газрын бага шатраа
Айлсан хоршин тоглож байг
Эх захаа мэдэг гэж
Эрээн тал нь удаалж байг
Энэ газрын бага шатраа
Эмс охид нь тоглож байг
Дайны сүлдтэй бүтэн шатраа
Дээдэс язгуур нь нууцалж байг
Харийн дайсны шуналыг марталгүй
Хар тал нь эхэлж байг (ЗХАДЗХТС, 2023:139)

гэж тайлбарлаж байна” (Батзориг, 2016). Эшт шатрыг ийнхүү газар нутгаа харийн дайснаас хамгаалж байхыг сануулж зохиосон болохоор хар талаасаа эхлэн нүүж, “хэлж ирдэггүй хий барам”-ын дарлага болгох зан үйлийн утга бэлгэдэл үүссэн бололтой.

Цаашилбал гарааны нүүдлийн нууц дохио, далд утгыг туульст:

Хааны урдаас нүүвэл
Халдах дайсангүй амгалан гэнээ
Баатрын урдаас нүүвэл
Баахан түгшүүртэй яваа гэнээ
Бэрсийн урдаас нүүвэл
Бултах анд яваа гэнээ
Амар мэндийн гараа нь гэнээ
Ахин уулзахын ерөөлтэй гэжээ (ЗХАДЗХТС, 2023:140)

Энэ үгийг нарийн ухвал, энх цагийн наадам бол хааны урдаас нүүдэг, дайн тулаанд дуудвал баатрын урдаас нүүдэг, ан гөрөөнд яваа бол бэрсийн урдаас нүүдэг шатрын журам, харилцааны соёлыг зааж байна. Энэ нь Эшт шатрын гарааны нүүдлийн далд утгын тухайд судлаачийн мэдээлсэн “Шатрын өмнөх хүүгээр эхэлбэл “Дайн самууны хэл дуулгаж явна”, Бэрсийн өмнөх хүүгээр эхэлбэл “Ан авд явж байна”, тэмээний өмнөх хүүгээр эхэлбэл “Жинд явж байна”, морины өмнөх хүүгээр эхэлбэл “Унаа малгүй явгарчихлаа, туслаач”, бухын урдах хүүгээр эхэлбэл “Нүүдэл хийж явна” гэх утгуудыг илэрхийлнэ” (Батзориг, 2016) гэсэн тайлбарыг баталж байна.

Шатрын цээр гэж бий. “Монгол шатар нь нөгөө этгээдийн юмыг дуустал идэхийг цээрлэх бөгөөд хэрэв бусдын юмыг идэж дуусгаад ганц ноёныг үлдээвэл тэнцсэнд тооцдог. Монгол шатар нь морин шаагаар хожилт хийхийг цээрлэнэ” (Санжаажамц, 1968: 18). Энэ цээрийг мөн домог-туульд:

Нүцгэн хаан үлдээдэггүйн учир нь
Наадгай өргөө хүндэлдэг нь тэр ээ
Мориор өрөг эхэлдэггүйн учир
Молор эрдэнэ хайрладаг нь тэр ээ (ЗХАДЗХТС, 2023: 139)

хэмээн шууд тайлбарлажээ.

“Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын туульс” хэмээх энэ домгийн “Шатрын тангараг” хэмээх сүүлийн бүлэгт шатрын дүрсүүдээс тэргийг онцлон магтаж:

Уулын эзэн сарлагийн бухандаа
Ум зандан ханхай хөллөхийн учир нь
Арван зүгийн эрдэнэс ачаалж
Андгай давсан шатарчинд өгөх юм гэнэ (ЗХАДЗХТС, 2023:140)

гэхчлэн тэргэндээ арван зүгийн эздийн эрдэнэсийг ачаалан байхыг бэлгэдэхийн хамтаар шатар тоглохдоо эрдэнийн зүйлсээр андгай тангараг тавьж тоглодог байсан эртний ёсны ул мөрийг тусгасан байна. Андгай тавих гэдэг бол эртний домог туульсын баатрын зан төрхийг илтгэдэг гол өгүүлэмж болно. Эртний Грекийн домог зүйд Сфинкс Эдип хаантай шатар тавьж, оньс үг таалцаад ялагдвал хот улсыг өгөх андгай тавьдаг бол монгол домог зүйд Эрхий мэргэн тэнгэрт гарсан долоон нарыг харваж чадахгүй бол “Хар ус уухгүй, хагд өвс идэхгүй” гэж андгайлдаг. Эрдэнэс ачаалсан шатрын тэрэгний энэ жишээнээс үзэхэд монгол домог зүйд ч бас шатар тоглоод “Арван нүүдэл алдалгүй шалж, ацан мад тавилгүй хожвол арван зүгийн эздийн эрдэнэсийг өгөх”, “Таван нүүдэл алдалгүй шалж, хааныг үлдээлгүй хожвол таван тивийн эздийн эрдэнэсийг өгөх” (ЗХАДЗХТС, 2023:140) андгай тангараг бүхий домгийн зүйл байсан бололтой.

Тус домог-туулийн төгсгөлд шатрын ухаанд нэвтэрч чадсан хүн “Арван жил болсон аалзны мөрийг андахгүй мэдэх”, Хорин жил болсон хорхойн мөрийг хоёргүй таньдаг болох”-оос эхлээд, “Мангасын бодлыг магад мэдэх”, “Шулмын бодлыг шуугин мэдэх”, “Дайсны бодлыг дайрч мэдэх”, “Өвгөдийн бодлыг ухаарч мэдэх”, Ухаантны бодлыг уудлан мэдэх”, “Буурлын бодлыг тосож мэдэх”, “Балчрын бодлыг баахан мэдэх”, “Хааны ухаанд хариулж мэдэх”, “Лусын үйлийг лав мэдэх”, “Тэнгэрийн нууцыг таньж мэдэх” (ЗХАДЗХТС, 2023: 141) хүртэл эрдэмтэй болно гэжээ. Монгол туульсын баатрууд ч “Арван жил болсон аалзны мөрийг мөшгөөд”, Хорин жил болсон хорхойн мөрийг мөшгөөд” байдаг.

Хэлэлцүүлэг

Аман зохиолын төрөл зүйлийн онолоор, хүүрнэн өгүүлэх аман зохиолын эртний домог (myth), тууль (epic) гэдэг хоёр төрөл зүйлийг ялгах анхны шалгуур нь гол баатар нь тэнгэр бурхан байна уу, хүн байна уу гэдэгт удаах шалгуур нь хэн шийдвэрийг гаргаж, хүчийг эзэмшиж, хэн ялалтыг авчирч байна вэ гэдэгт оршино. Эртний домогт бол ямагт тэнгэр нараас хүнд заан соёрхож, тэнгэр нарын шийдвэр, оролцоотойгоор үйл хэрэг өрнөн бүтэж байгаа гэж үзүүлдэг бол баатарлаг туульст хүнийг дүрслэгдэхүүнийхээ төвөд тавьж, туульсын баатар нь тэнгэр нарын эрхшээлийг сөрөн босож, хүний хүчин чадлыг батлан тунхаглахын төлөө тэмцэж байдаг.

“Хөх өвгөн сахиустай хөд модон шатрын туульс” хэмээх энэхүү туурвилд гарч буй их дайны өгүүлэмж нь хорчины “Галавын үлгэр”-т гардаг мангасуудыг дарсан тэнгэр нарын их дайныг санагдуулж байна. Хорчины “Галавын үлгэр”-т хүнээр хүнсэлдэг аймшигт мангасуудыг дээд тэнгэрээс хүнд хувилж буусан тэнгэр нар дарж өгч, газар дэлхийг цэвэрлэж дуусаад, тэнгэртээ буцах нь буцаад, газар дэлхий дээр уул, ус, газрын эзэн болж үлдэх нь үлддэг. Түүнчлэн “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын туульс” хэмээх энэ урианханы туульст

Хөвөн үүл нөмрөгтөнгүүд
Хөх могой хөсөгтөн болов
Тэнгэр хаяа чуулгатангууд
Тэвэр могой хөсөгтөн болов (ЗХАДЗХТС, 2023:136)

гэж тэнгэр нар “Харь тивийн түмэн барам”-ыг устгаж, тонилгохыг нь тонилгосноос гадна хөсөг болгохыг нь хөсөг болгож авсан тухай өгүүлж байна. Энэ нь монгол бөө мөргөлд лусаар хөллөсөн бөө нарын өмсгөлд олон зүйлээр могойг дүрсэлдэг заншлын учрыг ч сануулахын хамтаар тэнгэр нарын шийдвэр, оролцоог тунхаглаж байна. Энэ үүднээс авч үзвэл “Хөх өвгөн сахиустай хөд модон шатрын туульс” хэмээх энэхүү шүлэглэсэн жишээнд “Муу барам” буюу хийсвэр хар хүчний түрэмгийллийг дарсан их дайны баатарлаг үйл хэргийг үзүүлэхдээ хүний хүчин чадлыг огт батлаагүй, харин ч эсрэгээр дээд тэнгэр нар буюу хийсвэр хүчний оролцоог тунхаглаж байгаа тул бид энэ туурвилыг домог зүйн бүтээл гэж үзэж байна.

Дүгнэлт

“Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын туульс” хэмээх шүлэглэсэн туурвилыг бид орон, цагийн тохиргоо хийгээд дүр, өгүүлэмжийн талаас нь шинжлээд, аман зохиолын чухам аль төрөл зүйлсэд хамаарах тухайд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. “Хөх өвгөн сахиустай хөд модон шатрын туульс” хэмээх энэхүү шүлэглэсэн туурвилын “Газар дэлхий үүсэв” хэмээх тэргүүн бүлэг нь Наран Саран хоёр эрхэс газар дэлхийг хамтран бүтээгээд, Хурмастын найр дээр тэнгэр нарын өмнө түүнийгээ харж сахиж явах тангараг тавьж байгаа өвөрмөц өгүүлэмж бүхий ертөнцийн үүслийн монгол домгийн нэгэн шинэ хувилбар мөн байна.

2. “Дайн болов”, “Тэнгэрийн аврал” гэсэн бүлгүүд нь хүн төрөлхтнөөс газар дэлхийг нь булаах гэсэн “Муу барам” буюу харь муу хүчний түрэмгийллийг дарсан их дайныг үзүүлэхдээ хүний хүчин чадлыг бус, дээд тэнгэр нарын хүчийг тунхаглаж байгаагаараа тус туурвилын домог зүйн шинжийг дахин баталж байна.
3. “Шатар үүсэв”, “Шатрын жаяг”, “Шатрын тангараг” хэмээх сүүлийн гурван бүлэг нь хүн төрөлхтөнд арга ухаан суулгах гэж тэнгэр эрхсүүд шатрыг бүтээж, хүнд өгсөн хэмээн хүний оюун ухааныг бус, дээд тэнгэр нарын шийдвэр соёрхлыг магтан дуулсан учраас тус туурвил нь төрөл зүйлийн хувьдаа баатарлаг туульс биш, соёлын үүслийн домгийн жишээ болж байна.
4. Энэ бүхнээс нэгтгэн дүгнэвэл “Хөх өвгөн сахиустай хөл модон шатрын туульс” хэмээх энэхүү өвөрмөц туурвил нь эртний монголчуудын ертөнцийн үүслийн домог хийгээд шатар үүссэн тухай соёлын үүслийн домгийн өвөрмөц хувилбарыг өөртөө агуулсан, Наран Саран эрхсийн домог болоод Тэнгэр нарын домгуудтай нэгэн эх сурвалжтай, монгол домог зүйн нэгэн томоохон жишээ мөн байна.

Ном зүй

А. Монгол хэлээр:


- Батзориг, А.** (2016). *100 буудалт шатар*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй. [Batzorig, A. *100 buudalt shatar* [100 board chess]. Ulaanbaatar: No press. 2016]
- Батзориг, А.** (2023). Дайчин засгийн хошууны урианханууд эртний монголчуудын эшт шатрын өв тээгчид болох нь. “Засагт хан аймгийн Дайчин засгийн хошууны түүх соёл” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, №1: 126-142. [Batzorig, A. The Uriankhans of the Daichin Zasag are the bearers of the chess heritage of the ancient Mongols. *Proceedings of the conference “History and Culture of Daichin Zasag Banner of the Zasagt Khan Province”*, №1: 126-142.]
- Дулам, С.** (1992). *Дархад бөөгийн уламжлал*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр. [Dulam, S. *Darkhad boogiin ulamjlal* [Tradition of Darkhad shaman]. Ulaanbaatar: NUM Press. 1992]
- Дулам, С.** (1989/2009). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: Битпресс. [Dulam, S. *Mongol domog zuin dur* [Mongolian mythological figure]. Ulaanbaatar: Bitpress LLC. 2009]
- “Монгол үндэстний ижилслийг илтгэх тэмдэг, бэлгэдлийн судалгаа” төслийн тайлан.** (2018). Улаанбаатар: МУ-ын Засгийн газар. [“*Mongol undestnii ijilslig iltgekh temdeg, belgedliin sudalgaa*” *tosliin tailan* [Report of the research project “On characters and symbols that indicate the identity of the Mongolian nation”]. Ulaanbaatar: Government of Mongolia. 2018]

Нандинбилиг, Г. (2019). Хорчины Галавын үлгэр дэх домог зүйн дүр, өгүүлэмж. *Монгол судлал, Vol. XLIII, №520*: 124-132. [Nandinbilig, G. Characters and motifs of “Story of the Galav” of the Qorchins. *Mongolian Studies, Vol. XLIII, №520*: 124-132.]

Сүхбаатар, О. (1999). *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар: Адмон принтинг. [Sukhbaatar, O. *Mongol khelnii khari ugiin toli* [Dictionary of Mongolian foreign words]. Ulaanbaatar: Admon printing. 1999]

Б.Гадаад хэлээр:

Dulam, S. & Vacek, J. (1983). Mongolian Mythological Text. *Studia Orientalia Pragensia, Vol. XII*, Prague: Charles University. [Dulam, S. & Vacek, J. Mongol domog zuin text. *Studia Orientalia Pragensia, XII* [Монгол домог зүйн текст]. Прага: Карлын их сургууль. 1983]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.